

Эрхэм хүндэт эцэг эх/асран хамгаалагч танаа

Саяхан болсон цочирдом хэрэг явдал нь манай сургуулийн сурагчдад шууд болон шууд бусаар нөлөөлсөн байж болох юм. Энэхүү эмгэнэлт үйл явдалд нэрвэгдсэн бүхий л гэр бүл, ард иргэдтэй бид сэтгэл зүрхээрээ хамт байна.

Хүн бүрийн хариу үйлдэл харилцан адилгүй байдаг учир өнөөдөр болон ирэх өдрүүдэд та болон таны хүүхдэд олон янзын байдлаар нөлөөлж болзошгүй юм. Зарим нь маш их эмзэг болж, зарим нь бусадтай ярилцахыг хүсэх боловч зарим нь тэгэхийг хүсэхгүй байж болох юм. Цаг хугацаа өнгөрөх тутам хүмүүсийн хариу үйлдэл нь өөрчлөгдөж болох ба дээр дурдсан өөрчлөлтүүд нь ийм төрлийн хэргийн дараа гарах хэвийн үзэгдэл юм. Хүүхэд тань өөрийнхөө санааг зовоож байгаа асуудлыг хүссэн үедээ тантай хуваалцахад бэлэн гэдгээ та хүүхэддээ ойлгуулвал зохино.

Хүүхэд залуучуудад хүргэвэл зохих хоёр чухал мессеж нь:

- Бид бүгд сэтгэлээр унаж, эмзэг болсон үедээ бусдаас тусламж хүсэх хэрэгтэй.
- Хэрэв та өөртөө эсвэл найздаа санаа зовж байгаа бол итгэж болох насанд хүрсэн хүнд энэ талаар хэлэх нь чухал.

Дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргасан "Хүүхэд, залуучуудад олон нийтийг цочирдуулсан үйл явдлын дараах сэтгэлийн хямралыг даван туулахад туслах нь" хуудаснаас үзнэ үү. Шаардлагатай тохиолдолд нэр дурдсан байгууллагуудын үйлчилгээнд хамрагдахыг зөвлөж байна.

Манай сургуульд сурагчдад зориулсан нэмэлт туслалцаа авах төрөл бүрийн боломжууд байдаг. Үүнд сургуулийн зөвлөх ажилтны дэмжлэг, туслалцаа багтана. Хэрэв хүүхдэдээ нэмэлт туслалцаа авах шаардлагатай бол сургуулийн захиралтай холбоо барина уу.

Хэрвээ та хүүхдийнхээ сургуультай холбогдох хүсэлтэй бөгөөд танд англи хэлний орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн ярихыг хүссэн хэлээ мэдэгдэн, сургуультай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Уг үйлчилгээ нь үнэ төлбөргүй.

Хүндэтгэсэн

Захирал